

Жишээ баримт ашиглан, дүрслэн тайлбарласан эх зохиож бичих

(Сурах бичгийн 113-114 дүгээр хуудас)

1

Сэдэв сонгох

2

Төлөвлөгөө гаргах

3

Цуглуулсан материалыг эмхэлж,
нэгтгэх

4

Төлөвлөгөөний дагуу дүрслэн
бичих

СЭДВИЙГ ЯАЖ СОНГОХ ВЭ?

Сэдэв сонгох алхам

1. Сэдвийн жагсаалт гаргах



2. Дараах 3 асуултын дагуу тунгаан бодож, бичих СЭДВЭЭ СОНГОХ

1. Аль нь илүү чухал вэ?

Өөртөө илүү сонирхолтой эсвэл бусдад нэг хүргэх юм сан, энэ бол чухал гэснээ сонгох

2. Би аль сэдвийн талаар мэдлэгтэй вэ?

Өөрийнхөө уншиж, судалж байсан туршлагаа бодох

3. Судлах эх сурвалж байгаа юу?

Түүний тухай судлах ном, сонин, сэтгүүл, радио, нэвтрүүлэг, музей, интернет .

Сонгосон сэдвээ яаж нарийвчлах вэ?

Цаг хугацаанд төвлөрөх

Тодорхой үе, цаг хугацааг сонгож авах
Жишээ нь: Бөхөн (1980-2020)

Тодорхой байршилд төвлөрөх


Тухайн сэдвийн хүрээнд тодорхой газар, байршлыг сонгох
Жишээ нь: Бөхөн (Монгол)

Ангиллыг анхаарах

Тухайн сэдвийн ангиллыг анхаарч сонгох
Жишээ нь: Бөхөн (монгол, соргог)

Сэдвийн хүрээнд дэвшүүлэх асуудлыг тодорхойлох


Ямар өнцгөөс харж бичмээр байна? гэдэгт анхаарах
Жишээ нь: Бөхөн (ховордож байгаа)



Тайлбарласан эх найруулж бичих ТӨЛӨВЛӨГӨӨ гаргаарай.

Материал цуглуулахын өмнө төлөвлөгөө гаргах нь:

- Мэдээлэл цуглуулахад
- Баримт мэдээллийг бүлэглэхэд
- Баримт мэдээллийн уялдааг тогтооход
- Санааг давхардуулахгүй, эсвэл орхихгүй байх зэрэгт тустай.



Бөхөнгийн тухай дараах баримтыг уншаарай.

Нэршил

Бөхөнгийн эмийг шаргачин, эрийг нь ооно, үр төлийг нь янзага гэнэ. Бас өөрөөр эмийг нь хэрэгчин, эрийг нь хэржин ч гэж нэрлэдэг.

Монгол бөхөн сүүлчийн мөстлөгийн үед арслан заан, үст хирс, сэлмэн соёот зэрэг өнөө үед устаж мөхсөн амьтадтай зэрэгцэн оршиж байсан эртний эрмэл амьтан.

Биеийн онцлог

Монгол бөхөнгийн хамрын хөндий нь бусад туруутантай харьцуулахад илүү том бөгөөд их хэмжээний хүйтэн агаар хамрын хөндийд байрлах маш олон тооны хялгасан судсууд бүхий хананы ачаар түргэн зуур бүлээцэж гүйх үед нэн шаардлагатай дулаан агаараар уушгийг хангадаг. Мөн зуны халуунд амьсгалах агаарыг зохицуулж өгдөг.

Тэр давжаа биетэй ч толгойгоо доош гудайлган бөхийж давхидаг. Нарийн хөлтэй. Тэгсэн мөртлөө цагт 80 км цаг хүртэл хурдалж чаддаг.



Амьдрах орчин, тархац

Монгол бөхөн цөлөрхөг хээрийн эрүүл байдлыг илтгэдэг чухал амьтан. Монгол бөхөн оршсоор байна гэдэг нь говь цөлийн экологийн тэнцвэрт байдал алдагдаагүйн нотолгоо болдог. Монгол бөхөн эдүгээ зөвхөн Их нууруудын хотгор, Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний хүрэн талд голчлон байршиж байна.

Хоол тэжээл

Говийн хялгана, таана хөмүүл, баглуур, шарилж зэрэг гучаад төрлийн өвс ургамлаар хооллодог. Хавар өвс ногоо нялх шүүслэг үед бол бараг ус уудаггүй байна.

Бөхөнгийн тоо толгойн тухай мэдээллийг уншаад, нэгтгэж харуулаарай.

Дэлхийд зөвхөн Монголд байдаг монгол бөхөн сүүлийн жилүүдэд идэш тэжээлийн хомсдол, их хүйтрэл, халдварт өвчний улмаас хорогдож 2018 оны 12 дугаар сарын тооллогоор 3800 орчим тоо толгой үлдээд байсан юм. Тэгвэл Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын мэргэжилтнүүд, “Бөхөн хамгаалах сүлжээ” багийнхан хамтарч 2020 оны нэгдүгээр сард хийсэн тооллогоор 5070 орчим монгол бөхөн тоологджээ.

2014 оны байдлаар 15 мянган монгол бөхөнтэй байв.

1994 онд Монгол-Германы хамтарсан судлаачдын тооллогоор 1600 гаруй, 1997 оны 8 сард Монгол-Оросын хамтарсан биологийн экспедицийн судалгаагаар 860 гаруй монгол бөхөн байгааг тодорхойлсон байна... (Амгалан 1997, 1998)

2005 оны байдлаар Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний талд нийтдээ 1500 толгой бөхөн үлджээ (Л.Амгалан, Б.Чимэддорж 2005)

1982 онд 130 гаруй бөхөнтэй байснаа 1983-1984 оны зуднаар 30 хүрэхгүй тоотой болж, 1993 онд 70 гаруй, 1998 онд 50 орчим толгой болсон байна (С.Бадрах 1993, С.Шар 1998)

2010-2012 оны хооронд хийсэн Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-гийн хөтөлбөрийн газрын хамтарсан судалгаа тооллогын дүнгээр, монгол оронд дунджаар 8000 толгой монгол бөхөн байна гэж судлан тоолжээ.



Бөхөнгийн тоо толгойн тухай мэдээллийг уншаад, нэгтгэж харуулаарай.

Дэлхийд зөвхөн Монголд байдаг монгол бөхөн сүүлийн жилүүдэд идэш тэжээлийн хомсдол, их хүйтрэл, халдварт өвчний улмаас хорогдож **2018 оны** 12 дугаар сарын тооллогоор **3800** орчим тоо толгой үлдээд байсан юм. Тэгвэл Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын мэргэжилтнүүд, “Бөхөн хамгаалах сүлжээ” багийнхан хамтарч **2020 оны** нэгдүгээр сард хийсэн тооллогоор **5070** орчим монгол бөхөн тоологджээ.

2014 оны байдлаар **15 мянган** монгол бөхөнтэй байв.

1994 онд Монгол-Германы хамтарсан судлаачдын тооллогоор **1600** гаруй, **1997 оны** 8 сард Монгол-Оросын хамтарсан биологийн экспедицийн судалгаагаар **860 гаруй** монгол бөхөн байгааг тодорхойлсон байна... (Амгалан 1997, 1998)

2005 оны байдлаар Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний талд нийтдээ **1500 толгой** бөхөн үлджээ (Л.Амгалан, Б.Чимэддорж 2005)

1982 онд 130 гаруй бөхөнтэй байснаа **1983-1984** оны зуднаар **30 хүрэхгүй** тоотой болж, **1993 онд 70 гаруй, 1998 онд 50 толгой орчим** болсон байна (С.Бадрах 1993, С.Шар 1998)

2010-2012 оны хооронд хийсэн Биологийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-гийн хөтөлбөрийн газрын хамтарсан судалгаа тооллогын дүнгээр, монгол оронд дунджаар **8000 толгой** монгол бөхөн байна гэж судлан тоолжээ.

Он	Тоо толгой
1982	130 гаруй
1983-1984	30 хүрэхгүй
1994	1600
1997	860
1998	50 орчим
2005	1500
2010	8000
2014	15000
2018	3800
2020	5070



Бөхөнгийн хорогддог шалтгааны тухай мэдээллийг уншаад, нэгтгэж харуулаарай.

2014 оны байдлаар 15000 монгол бөхөнтэй байв. Харамсалтай нь, 2017 онд дэгдсэн бог малын **мялзан өвчин**, **зудны улмаас монгол бөхөн нэг дор олон мянгаараа хорогдсон** гашуун түүх бий.

Таван хошуу малын өвчин болох **омруу өвчинг тусахдаа маш хүнд тусдаг байна.**

1990-ээд онд монгол бөхөнгийн эврийг гадагш гарган зарж борлуулах нь их болсноос **хууль бусаар бөхөнг агнах** явдал ихэсчээ.

Бөхөн **гууртдагаасаа болж таргалах, хүнд нөхцөл байдлыг даах, бэрхшээл давах чадвар доройтдог** нь хорогдлын шалтгаан бас болж байна. Эдгээрээс гадна Монгол бөхөнгийн **гол дайсан нь бүргэд** шувуу юм.

Саарал чоно, шүлүүс мий, тас, цармын бүргэд зэрэг махан идэшт хөхтөн болон шувууд монгол бөхөнг шууд барьж иднэ.

Монгол бөхөнгийн **эврийг** Дорно дахины ангаах ухаан ардын **эмчилгээнд, махыг нь нутгийн хүн ард хоол хүнсэндээ** эртнээс **ашиглаж, хайр найргүй авласнаас, мөн Монгол бөхөнгийн амьдрах нутаг тархац нь багасан хумигдсанаас** шалтгаалан тоо хэмжээ нь эрс буурсан.

Монгол бөхөнгийн төрж өсөж, идээшлэн дассан нутаг орон, бэлчээр усыг нь хүн болон гэрийн тэжээвэр мал түрэн эзлэх болж, тэдний бэлчээр нутгаас хороосоор байна. **Цас зуд ихтэй хүйтэн өвөл болон хавар ихээхэн хэмжээгээр турж эцэн өлбөрч, мөн осгон хөлдөж үхэх явдал их байдаг.**

Хорогддог шалтгаан

1. **Мялзан, гууртах, омруу зэрэг өвчнөөр өвчилснөөс**
2. **Зуд, хүйтрэлт зэрэг цаг уурын нөхцөлийн улмаас**
3. **Бүргэд, чоно, шилүүс, мий, тас зэрэг махан идэшт хөхтөн болон шувууд бөхөнг барьж идсэнээс**
4. **Эврийг уламжлалт анагаах ухаанд хэрэглэхээс гадна гадагш гарган зарж борлуулах, махыг хүмүүс хоол хүнсэндээ хэрэглэснээс**
5. **Амьдрах нутаг, тархац нь хумигдсанаас хорогддог байна.**

Дараах 3 цогцолборыг дүрслэн тайлбарлаж бичээрэй.



Дүрслэн бичих

1. Баримт мэдээлэлд үнэлгээ дүгнэлт өгч бичих
2. Баримт мэдээлийг уншаад, аль нэг үг, өгүүлбэрийн санааг дүрсэлсэн үг хэллэг (уран дүрслэл)-ээр илэрхийлэх, солих, зарим үгийг тэмдэг нэрээр тодотгох
3. Аль нэг баримт мэдээллээс ямар сэтгэгдэл, мэдрэмж төрснөө бичих
4. Зарим үг хэллэгийг хэлц үгээр солин найруулах зэргээр ажиллана.

Нэршил

Бөхөнгийн эмийг шаргачин, эрийг нь ооно, үр төлийг нь янзага гэнэ. Бас өөрөөр эмийг нь хэрэгчин, эрийг нь хэржин ч гэж нэрлэдэг.

Монгол бөхөн сүүлчийн мөстлөгийн үед арслан заан, үст хирс, сэлмэн соёот зэрэг өнөө үед устаж мөхсөн амьтадтай зэрэгцэн оршиж байсан эртний эрмэл амьтан.

Бөхөнгийн онцлог

Монгол бөхөнгийн хамрын хөндий нь бусад туруутан харьцуулахад илүү том бөгөөд их хэмжээний хүйтэн агаар хамрын хөндийд байрлах маш олон тооны хялгасан судсууд бүхий хананы ачаар түргэн зуур бүлээцэж уушгийг гүйх үед нэн шаардлагатай дулаан агаараар хангадаг. Мөн зуны халуунд амьсгалах агаарыг зохицуулж өгдөг.

Тэр давжаа биетэй ч толгойгоо доош гудайлган бөхийж давхидаг. Нарийн хөлтэй. Тэгсэн мөртлөө цагт 80 км цаг хүртэл хурдалж чаддаг.

Ховордож байгаа шалтгаан

Мялзан, гууртах, омруу зэрэг өвчнөөр өвчлөх, зуд, хүйтрэх зэрэг цаг уурын нөхцөлийн улмаас, бүргэд, чоно, шилүүс, тас зэрэг махан идэшт хөхтөн болон шувууд бөхөнг барьж иддэгээс, эврийг уламжлалт анагаах ухаанд хэрэглэхээс гадна гадагш гарган, зарж борлуулах, махыг хүмүүс хоол хүнсэндээ хэрэглэх, амьдрах нутаг, тархац нь хумигдсанаас болж хорогддог байна.

Дараах баримтуудыг дүгнээрэй.

Монгол бөхөн сүүлчийн мөстлөгийн

үед арслан заан, үст хирс, сэлмэн

соёот зэрэг өнөө үед ~~устаж~~~~мөхсөн~~

амьтадтай зэрэгцэн оршиж байсан

~~эртний~~~~эрмэл~~~~амьтан~~. Дэлхийд

Монголоос өөр хаана ч байхгүй.^v

Өнө эртний түүхийн бодит
үзүүлэн

Ертөнцөөс арчигдсан

Эртний амьтдаас ганцаараа
торойж үлдсэн...

Эртний түүхээ эдүгээг хүртэл
сурталчилсаар яваа...

Амьд үзмэр.

Баримт мэдээллийг уншаад, тохирох газар дүрслэл оруулаарай.

Бөхөнгийн биеийн онцлог

Хандгай шиг монхор бөгөөд

Монгол бөхөнгийн хамрын хөндий нь бусад туруутантай харьцуулахад илүү том бөгөөд их хэмжээний хүйтэн агаар хамрын хөндийд байрлах маш олон тооны хялгасан судсууд бүхий хананы ачаар түргэн зуур бүлээцэж, гүйх үед нэн шаардлагатай дулаан агаараар уушгийг

Сум шиг хурдан.

Аагим бүгчим

хангадаг. Мөн зуны халуунд амьсгалах агаарыг зохицуулж өгдөг.

Бургас шиг нарийн хөл...

Шандастай амьтан байгаа биз.

Тэр давжаа биетэй ч толгойгоо доош гудайлган бөхийж давхидаг. Нарийн хөлтэй. Тэгсэн мөртлөө цагт 80 км цаг хүртэл хурдалж чаддаг.

Хөнгөн хөл...

Баримт мэдээллийг уншаад, тохирох газар хэлц, өөрийн санаагаа оруулж бич

Ховордож байгаа шалтгаан

Мялзан, гууртах, омруу зэрэг өвчнөөр өвчилнө.^v Зуд,

~~хүйтрэх^v зэрэг цаг уурын нөхцөлийн улмаас~~

~~жөрөгдөнө.~~ Бүргэд, чоно, шилүүс, тас зэрэг махан

идэшт хөхтөн болон шувууд бөхөнг барьж^v иднэ.

^v Эврийг уламжлалт анагаах ухаанд хэрэглэхээс гадна

гадагш гарган, зарж борлуулан, махыг хүмүүс хоол

хүнсэндээ хэрэглэнэ.^v

^v Амьдрах нутаг, тархац нь хумигдсанаас болж

хорогддог байна.

Чөмөг царцам их хүйтэн
тэднийг ертөнцөөс авч одно.

Ходоодоо баярлуулна.

“Орон гэртээ” хүнийрхүү
хандагчид ходоод, түрийвчээ
мялаана.

Бөхөнгийн зовлон үүгээр
дуусахгүй...

Нэг амийн төлөө нөгөө
амийг зольж...

Зарим хүний хар амиа
борлуулах аминчхан
үзлээс

Ноороггосноо дахин уншиж, сайжруулаарай.

Нэршил

Бөхөнгийн эхийг шаргалин, эрийг нь ооно, үр төлийг нь анзала гэнэ. Бас өөрөөр эхийг нь хэрэглэн, эрийг нь хэрэжин г гэж нэрлэдэг.

Онцлог

Монгол бөхөн сүүлгийн мөстлөгийн үед арслан заан, цст хирс, сэлмэн соёот зэрэг өнөө үед ертөнцөөс аргилдсан амьтадтай зэрэгцэн оршиж байсан өнө эртний түүхийн амьд үзүүлэн. Дэлхийд Монголоос өөр хаана ч байхгүй бодит үзлэр.

Монгол бөхөнгийн хамар хандгайнх шил монхор бөлөөд хөндий нь бусад туруутантай харьцуулахад илүү том бөлөөд их хэмжээний хүйтэн агаар хамрын хөндийд байрлах маш олон тооны хялгасан судсууд бүхий хананы агаар түрлэн зуур бүлээцэж уушгийг цүйх үед нэн шаардлагатай дулаан агаараар ханладаг. Мөн зуны аалим бүрчим халуунд амьсгалах агаарыг зохицуулж өгдөг. Тэр давжаа биетэй ч толгойгоо доош гудайлган бөхийж давхидал. Бурлас шил нарийн хэлтэй. Тэгсэн мөртлөө сүм шил хурдан. Цалт 80 км цал хуртэл хурдалж гадгал. Шандастай амьтан байгаа биз.

Тоо тоцгой

Хамгийн сүүлд "Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын мэрлээжилтнүүд, "Бөхөн хамгаалах сүлжээ" балийнхан хамтарч 2020 оны нэгдүгээр сард хийсэн тооллогоор 5070 орчим монгол бөхөн байна" гэжээ. Мазаамал бодвал олон юм шил саналдаж байна уу? 5000 малтай ганцхан айлын сүргийн тоо гээд бод доо. Ямар байна!

Тэгвэл юунаас болж тоо толгой нь илгээж цөөрөөд байна вэ? Малзан, гууртах, аируу зэрэг өвчнөөр өвчилнө. Бөхөнгийн зовлон үрээр дуусахгүй. Зуд, гэмөл царцал их хүйтэн тэднийг ертөнцөөс авч одно. Бүрлэд, чоно, шилүүс, тас зэрэг махан идэшт хөөхтөн болон шувууд бөхөнл барьж, ходоодоо баярлуулна. Нэг амийн төлөө нөгөө амийг зомьж, эврийг нь уламжлалт анагаах ухаанд хүмүүс хэрэглэхээс гадна гадалиг гарган, зарж борлуулах зэргээр "орон гэртээ" хүнийрхүү сэтгэлээр хандалгид түрийвгээ мялаана. Бас зарим хүний хар амиа борлуулах ашингхан үзлээс амьдрах нутаг, тархац нь хушигдаж хорогддог байна...

Хорогддог шалтгаан

Гэрийн даалгавар:

1. Амьдрах орчин, тархац, хоол тэжээлийн тухай баримт мэдээллийг дүрслэн тайлбарлаарай.
2. Өмнөх мэдээлэл дээр тулгуурлан, дүгнэлт бичээрэй.
3. Өөрийнхөө амьдарч буй орон нутагт ховордож байгаа амьтны тухай дүрслэн тайлбарлаж бичээрэй.

